



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№70 /284/

2022.04.11

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХАРЬЯА АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДАД ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ

Монгол Улсын Засгийн газрын ээлжит бус хуралдаан 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр хуралдаж цаг үеийн асуудал, иргэдээс гаргасан шаардлага, хүсэлтийг авч хэлэлцлээ. Энэ үеэр хэмнэлтийн горимоор ажиллах шийдвэр гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж эхлээд байна.

Тус хурлаас гарсан шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Батлан хамгаалах яамны харьяа агентлаг, байгууллагын дарга нартай өнөөдөр өргөтгөсөн шуурхай хуралдааныг зохион байгуулж салбарын хэмжээнд төсөв хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг чангаруулж, зардал хэмнэх талаар дараах үүрэг чиглэлийг өглөө.

Үүнд:

1. Том оврын жийп авто

машины хот доторх хэрэглээг зогсоох;

2.Тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг хэмнэлттэй, ухаалаг зарцуулалттай, төсөв, хөрөнгө шаардахгүй хэмжээнд тэмдэглэх;

3.Өдөр тутмын үйл ажиллагаанд гарч байгаа зардлууд /ус, цахилгаан, халаалт, бичиг хэрэг гэх мэт-ыг боломжит дээд хэмжээгээр хэмнэх;

4.Шинээр автомашин, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авахгүй байх;

5.Албан томиллоор ажиллах бүрэлдэхүүнийг цомхон бүрэлдэхүүнтэй болгох, үйл ажиллагааг нь нэгтгэх, үр бүтээлийг нь нэмэгдүүлэх зэргээр төсөв, зардлыг хэмнэх талаар тодорхой үүрэг өглөө.



БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРААС ТӨРӨН ГАРСАН ГАВЬЯАТУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон сайдын зөвлөлийн гишүүд тус салбараас төрөн гарсан гавьяатуудад хүндэтгэл үзүүлээ. Тухайлбал, Монгол Улсын гавьяат холбоочин, дайнд оролцсон ахмад дайчин, чөлөөнд байгаа дэд хурандаа Т.Бат-Очир, ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны профессор, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, чөлөөнд байгаа хошууч генерал Б.Эрдэнэбат, ҮБХИС-ийн зөвлөх профессор, доктор, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, чөлөөнд байгаа хошууч генерал Н.Жалбажав, ҮБХИС-ийн ахмад багш, гавьяат багш, чөлөөнд байгаа хурандаа Я.Мягмарсүрэн, Улсыг агаарын довтолгооноос хамгаалахын цэргийн

байлдааны сөнөөгч онгоцны 1 дүгээр зэргийн нисгэгч, гавьяат нисгэгч, чөлөөнд байгаа дэд хурандаа С.Шаравсамбуу, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нислэг эрхэлсэн нэгдүгээр-нисгэгч, гавьяат нисгэгч, хурандаа Н.Баясгалан, Цэргийн төв эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга, хүний гавьяат эмч, хурандаа Р.Баянмөнх, ЗХЖШ-ын цэргийн хөгжмийн алба, Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн дарга, урлагийн гавьяат зүтгэлтэн, асан чөлөөнд байгаа хурандаа Г.Цэрэнсүх, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн ахмад ажилтан, гавьяат тээвэрчин бэлтгэл ахлах ахлагч Ж.Моломжамц, "Бөртэ" ТӨААТҮГ-ын ахмад ажилтан, үйлчилгээний гавьяат ажилтан

Ё.Мягмарсүрэн нарын ахмадад хүндэтгэл үзүүлсэн юм.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт, аюулгүй байдал, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулан ажиллаж байгаа эрхэм хүндэт гавьяатууд та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Өнгөрсөн онд Монгол Улсын түүхэн томоохон тэмдэглэлт ойнуд тохиож, энэ жилийн хувьд тэмдэглэн өнгөрүүлэх завшаан гарсан. Энэ ч үүднээс Зэвсэгт хүчний 100, 101 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ. Бидний анхаарсан нэг ажил бол үйлс гавьяагаараа манлайлагчдынхаа ажлыг төр, засагт үнэлүүлэх, үүгээрээ дамжуулж Батлан хамгаалах салбар,

Зэвсэгт хүчнийхээ үнэлэмжийг дээшлүүлэхэд байлаа. 2021, 2022 онд Батлан хамгаалах салбараас 20 гаруй хүн гавьяат цолоор шагнагджээ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, мөн төр, засгаас манай салбарыг ихээхэн үнэлж байгаагийн тод илрэл гэж ойлгох хэрэгтэй. Эрхэлсэн албандаа үнэнч, үлгэр жишээчээр ажиллаж, байгаа та бүхэн салбарынхаа нэр хүндийг өндөрт өргөн, төрийн дээд цолоор шагнагдсан генерал, ахмадууд та бүхэнд сайдын зөвлөл болон Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт бие бүрхэлдэхүүний нэрийн өмнөөс талархал илэрхийлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе" гэлээ.

Мөн ахмад дайчин, гавьяат холбоочин, чөлөөнд байгаа дэд хурандаа "Гавьяатууд бид Батлан хамгаалахын сайдын хүндэтгэлийг хүлээнд авч байгаадаа маш их баяртай байна. Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын байгуулсан үйлс, хийж гүйцэтгэсэн ажил, үйл хэргүүд бидэнтэй салшгүй холбоотой учраас энэ ийм их хүндлэл хүлээж байгаа болов уу. Миний хувьд өндөр насыг наслчихлаа, Жанжин тугийнхаа намираанд жаргал зовлонг ч туулж явлаа, жагсаалын сүрийг бадрааж явлаа. Би жанжин туг, дайчин туг, алтан соёмбот төрийн далбаагаа шүтэж явдаг хүн. Тийм ч учраас Ерөнхийлөгчийн өмнө гавьяат цолоор шагнагдахдаа Монгол Улсын төлөө зүтгэе гэж ёсолсон. Батлан хамгаалахын сайдын хүндэтгэлийг хоёр ч удаа хүртлээ, тун баяртай байна. Та бүхэндээ эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Цэлгэр сайхан ирээдүй, цэлийж байна" хэмээв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 2	☁️ -13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,150.00	3,180.00
EUR 🇪🇺	3,505.00	3,550.00
CNY 🇨🇳	507.00	509.00
RUB 🇷🇺	36.00	37.00
JPY 🇯🇵	26.50	27.70
KRW 🇰🇷	2.62	2.68

ЗУРХАЙ



2022.04.11 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 10/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихсэнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.11-19.36

Барилдлага:

РАШААН

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

МУНХРАХУЙ

СУУДАЛ: Төмөр

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, угаал үйлдэх, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч хүч ихсэнэ.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал эрч хүч ихсэнэ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,629 /69.9%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,933 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,034,179 31,8% 116,811 /3,6%/
НИЙТ БАТЛАГДСАН 8437 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 2	ЭДГЭРСЭН 8314

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 499,199,857

Эдгэрсэн
Нийт: 448,760,607

Нас барсан
Нийт: 6,203,372

Эрүүл мэндийн газрын шалтгааныг нь ТӨР ХАРИУЦАН ТӨЛӨХ ИРГЭД

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2% -ЦАР

- Тэтгэвэрээ өөр тогтоомол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн гэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхсөн гэрлэлт иргэн
- Хүүхдээ 2 дугар бол 3 нас хүртэл нь өсгөн байхуйлж хөдөлмөр үзэхгүй
- Хүлээлт цэргийн албан хаагч
- Ал эрхэлж байгаа иргэн

сая 8,400Т 0-----100,800Т жилд

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1% -ЦАР

- 0-18 насны хүүхэд

сая 4,200Т 0-----50,400Т жилд

Та өөрийн ЭМД-ын шалтгааныг мэдэхийн тулд байгаа газраасаа, холбаран шалтгаан болонгой WWW.EMD.GOV.MN

Цахим шууданд

БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА



БХЯ-ны Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлөөс Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам болон ёс зүйн мэдлэг олгох цуврал сургалтыг БХЯ-ны харьяа байгууллагын бие бүрэлдэхүүнд бүсчлэн зохион байгууллаа.

Өнөөдөр тус сургалтад Цэргийн төв эмнэлэг, "Соёмбо редакт", Батлан хамгаалахын төв архив, ЦДБЭЧ, "Алдар" спорт хороо зэрэг бусад БХЯ-ны харьяа байгууллагууд хамрагдлаа.

Сургалтыг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын

генерал Ж.Болдбаатар нээж хэлсэн үгэндээ "Ёс зүй гэдэг асуудал бол төрийн алба хаагч, цаашлаад хувь хүн бүрд тавигдаж буй нэн тэргүүний асуудал. Ёс зүйтэй төрийн алба хаагчаас ёс зүйтэй үйлдэл гардаг. Мөн ёс зүйтэй байж төрийн албыг төгөлдөржүүлнэ. Тиймээс Батлан хамгаалахын сайд болон Батлан хамгаалахын төрийн нарийн бичгийн дарга нарын тушаалаар томилогдсон хэн бүхэн ёс зүйг эрхэмлэн ажил албаа явуулах зорилгыг тавьж ажиллах ёстой. Энэ ч үүднээс БХЯ-ны Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл Авлигатай

тэмцэх газартай хамтран энэ сургалтын зохион байгуулж байна. Тиймээс та бүхэн хувь хүний хандалга болон албандаа төрийн алба хаагчийн ёс зүйг хэвшүүлэн ажиллахыг уриалж байна" гэв.

Тус сургалтад урилгаар Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн мэргэжилтэн Н.Батчулуун, М.Жамьянцогжил нар оролцож авлига хээл хахуул, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр лекц уншлаа.



БАТЛАН ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ХЯНАН ШАЛГАГЧ ДОРНОГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМГУУДАД АЖИЛЛАВ



Улс орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчин, тэр дундаа барилгын цэрэг, инженерийн цэргүүдийн оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг их. Эл түүхээ төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцох буйгаар арвин түүхээ баяжуулсаар байна. Тухайлбал, өнөөдрийн байдлаар Цогтцэций сумын өртөө, барилга байгууламж, Таван толгой-Зүүн баян, Зүүн баян-Ханги чиглэлийн шинэ төмөр замын бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний 40 гаруй нэгтгэл анги байгууллагын 600 гаруй алба хаагч гар бие, сэтгэл зүрх нэгтгэйгээр оролцож байна.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 6-8 ны өдрүүдэд дээрх бүтээн байгуулалтын ажил явагдаж буй Дорноговь, Өмнөговь аймгуудад ажиллалаа. Энэ үеэр Зэвсэгт хүчний ангиудын үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэл, тулгамдаж буй асуудалтай нь газар дээр нь танилцаж судлахын зэрэгцээ шийдвэрлэх, цэргийн албаны зохион байгуулалтын байдалтай нь танилцсан юм. Мөн алба хааж буй цэргүүдтэй уулзаж, санал сэтгэгдлийг нь сонссон бөгөөд цэргүүд эх орныхоо бүтээн байгуулалтад гар бие

оролцож, халагдаад харихдаа мэргэжлийн чиг баримжаатай, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болж байгаагаа сэтгэл хангалуун байгаагаа энэ үеэр илэрхийлж байсан юм.

Түүнчлэн энэ үеэр Зэвсэгт хүчний 336 дугаар анги ажилласан бөгөөд ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Г.Гантөр ангийн товч танилцуулгыг хийж, тулгамдаж буй зарим асуудлын талаар мэдээлэл өгөв.

Үүний дараа Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатар бие бүрэлдэхүүнтэй уулзаж санал сэтгэгдлийг нь сонслоо.



"ЦЭРГИЙН НЭГ ӨДӨР" СЭДЭВТ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ЗХЖШ-ын Сургалтын бодлогын газрын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хэлтэс Rotary байгууллагын "Interact" клубийн гишүүд болох Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдтай хамтран "Эх оронч

хүмүүжил" олгох зорилгоор "Цэргийн нэг өдөр" сэдэвт сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг Зэвсэгт хүчний 013 дугаар ангид өнгөрсөн баасан гарагт амжилттай зохион явууллаа.

Сурталчилгааны үйл ажиллагаанд ЗХЖШ-

ын Сургалтын бодлогын газрын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн захирагч хурандаа Ч.Эрдэнэболд, ЗХЖШ-ын Сургалтын бодлогын газрын Суртал хүмүүжил, сэтгэл



зүйн хэлтсийн мэргэжилтэн дэд хурандаа О.Ганбаяр, Олон улсын 3450 дугаар Ротарийн 9 дүгээр бүсийн захирагч Н.Мягмаржаргал, Г.Ундрах, Ц.Баатар болон Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 60 сурагчид хүрэлцэн ирж

хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанд хамрагдлаа.

Rotary байгууллагын "Interact" клубийн гишүүд болох Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч нарыг хүлээн авч хөтөлбөр,

төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу галын бэлтгэл, цэрэг эх оронч хүмүүжил, ҮОХЗХ бэлтгэл хичээлүүдийг зааж, сургалтын төгсгөлд цэрэгжлийн буухиа тэмцээнийг зохион явуулсан юм.

